



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/504

Мандалговь

Г Тусгай зөвшөөрлийн эрх олгох,
түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай

Монгол Улсын "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.2, 7.4, 9 дүгээр зүйлийн 9.1.2, 13 дугаар зүйлийн 13.1, 16 дугаар зүйлийн 16.2.5 дахь заалт, "Архидан согтуурахтай тэмцэх тухай" хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.1.7, 7.1.8, 14 дүгээр зүйлийн 14.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Мандалын говийн хурд, Баянбулаг мандал, Мэнгэт баян булаг, Ундром Онги ХХК-ны архи согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрлийн эрхийг 2018 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс 2020 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр хүртэл хугацаагаар олгосугай.

Хоёр. Мандалын говийн хурд ХХК-д "Алтан хүнс" группын үйлдвэрлэсэн архи, согтууруулах ундаа худалдан борлуулах гэрээт борлуулагчийн эрхийг 2018 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс 2020 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр хүртэл хугацаагаар олгосугай.

Гурав. Цагаан зоо ХХК-ны тусгай зөвшөөрлийн эрхийг 11 дүгээр сарын 19-ны өдрөөс хууль дүрэм журмын хэрэгжилтийг биелүүлж зөрчлөө арилгах хүртэл хугацаагаар түдгэлдүүлсүгэй.

Дөрөв. ЭОЖИН, Мандалговь-Импекс, Дэлгэрэх-Өнгөт, Өглөг хурайлах, Санжаасүрэн ХХК-ны тусгай зөвшөөрлийн эрхийг 2018 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс тус тус хүчингүй болгосугай.

Тав. Ажиллах цагийн хуваарийг Мандалын говийн хурд, Баянбулаг мандал, Мэнгэтбаян булаг ХХК-д 08.00-24.00, Ундром Онги ХХК-д 08.00-20.00 цаг хүртэл хугацаагаар тогтоосугай.

48801054

Зургаа. Тусгай зөвшөөрлийн эрхийг олгосон шийдвэрийг холбогдох газруудад хуулийн хугацаанд мэдэгдэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), тухайн аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (О.Амарсанаа), Татварын хэлтэс (М.Туяацэцэг), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О. БАТ-ЭРДЭНЭ